

# “ЭРДЭНЭС СОЛЬЮШИНС” ХК

2021 оны 05 дугаар сарын 17-ны өдөр

№ТУЗТ 05/2021

Улаанбаатар хот

## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

Компанийн энгийн хувьцаа худалдан авах,  
худалдах сонирхолын зөрчилтэй хэлцэл хийх тухай

Компанийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.4, 5.5 дахь хэсэг, 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг, 55 дугаар зүйл, 56 дугаар зүйлийн 56.1 дэх хэсэг, 76 дугаар зүйлийн 76.1.6, 76.1.8, 76.1.17, 76.2 дахь хэсэг, 89 дүгээр зүйлийн 89.1, 89.2 дахь хэсэг, 91 дүгээр зүйлийн 91.2 дахь хэсэг, 92 дугаар зүйлийн 92.1, 92.2 дахь хэсэг, “Эрдэнэс сольюшинс ХК (“Компани”)-ийн дүрмийн 9 дүгээр зүйлийн 9.10.7, 9.10.14, 9.10.17, 20 дугаар зүйлийн 20.1, 20.4 дэх хэсэг болон Төлөөлөн удирдах зөвлөлийн 2021 оны 05 дугаар сарын 17-ны өдрийн ээлжит хурлын шийдвэрийг тус тус үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Төлөөлөн удирдах зөвлөлийн 2020 оны 03-р сарын 06-ны өдрийн №ТУЗТ 03/2020 тоот тогтоолын 6-р заалтад “Компани “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК-ийн 1 /нэг/ ширхэг нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн 301,000 /гурван зуун нэг мянга/ ширхэг хувьцааны 90 /ер/ хувь буюу 270,900 /хоёр зуун далан мянга есөн зуу/ ширхэг энгийн хувьцаа нэг бүрийг нь 1.18 /нэг төгрөг арван найман мөнгө/ төгрөгөөр буюу 319,662,000 /гурван зуун арван есөн төгрөг зургаан зуун жаран хоёр мянга/ төгрөгөөр худалдан авах гэрээ хийхийг Гүйцэтгэх захирал Ц.Хүдэрмөнхөд даалгасугай.” гэснийг “Компани “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК-ийн 1 /нэг/ ширхэг нь 1 /нэг/ төгрөгийн нэрлэсэн 301,000,000 /гурван зуун нэг сая/ ширхэг хувьцааны 70 /дал/ хувийг буюу 210,700,000 /хоёр зуун арван сая долоон зуун мянга/ ширхэг энгийн хувьцаа нэг бүрийг 1,18 /нэг төгрөг арван найман мөнгө/ төгрөгөөр нийт 248,626,000.00 /хоёр зуун дөчин найман сая зургаан зуун хорин зургаан мянга/ төгрөгөөр худалдан авах, гэрээ хийхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай” гэж өөрчилсүгэй.
2. Компани болон иргэн Б.Батхүүгийн хооронд байгуулагдах “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК-ийн Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ болон тэдгээртэй нийцүүлэн гарах аливаа гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
3. Компанийн тухай хууль болон “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК-ийн дүрэмд заасан хувьцаа эзэмшигчийн эдлэх эрх, хүлээх үүргийг “Эрдэнэс сольюшинс” ХК-ийн нэрийн өмнөөс төлөөлж “Эрдэнэс коммодитийс трейдинг” ХХК-ийн хувьцаа эзэмшигчдийн хуралд эдлэх, нэмж хувьцаа гаргах, нэмж гаргах энгийн хувьцааны үнэ тогтоох, компани төлөөлж гэрээ хэлцэл хийх эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
4. Компанийн эзэмшиж буй “Мөнгөн морь констракшн” ХХК-ийн 85 /наян тав/ хувь буюу 1 /нэг/ ширхэг нь 1/нэг/ төгрөгийн нэрлэсэн үнэтэй 342,176,000.00 /гурван зуун дөчин хоёр сая нэг зуун далан зургаан мянга/ ширхэг энгийн хувьцаанаас 80,512,000 /наян сая таван зуун арван хоёр мянга/ ширхэг энгийн хувьцаа нэг бүрийг 1,17 /нэг төгрөг арван долоон мөнгө/ төгрөгөөр буюу нийт 94,199,040.00 /ерэн дөрвөн сая нэг зуун ерэн есөн мянга дөч/ төгрөгөөр “Субашид тек” ХХК-д худалдахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д зөвшөөрсүгэй.
5. “Мөнгөн морь констракшн” ХХК-ны бусад хувьцаа эзэмшигчид энэ тогтоолын 4-т заасан хувьцааны тоо ширхэг, нэг бүрийн болон нийт үнээр тэргүүн ээлжид худалдаж авч болох хугацааг ажлын 15 хоногоор, “Мөнгөн морь констракшн” ХХК-д мэдэгдэх хугацааг ажлын 5 хоногт багтаан мэдэгдсүгэй.
6. Компани болон “Мөнгөн морь констракшн” ХХК хооронд байгуулагдах Хувьцаа худалдах, худалдан авах гэрээ, Эрх шилжүүлэх гэрээ болон тэдгээртэй нийцүүлэн гарах аливаа гэрээ, хэлцэл, баримт бичигт Компанийг төлөөлөн гарын үсэг зурах бүрэн эрхийг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д олгосугай.
7. Энэхүү тогтоолыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор Улсын бүртгэлийн ерөнхий газарт бүртгүүлэх, шаардлагатай бусад арга хэмжээг тухай бүр авч ажиллахыг Гүйцэтгэх захирал (Ц.Хүдэрмөнх)-д даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ  
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



/Т.ЗОЛБОО/